

ЕСУС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ
ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН АЛБАН ГАЗАР
47 EAST SOUTH TEMPLE STREET, SALT LAKE CITY, UTAH 84150-1200

2020 оны 5-р сарын 19

Хүндэт ах, эгч нар аа,

Сүмийн цуглаан, үйл ажиллагаанд эрсдэлгүй эргэж орох заавар

2020 оны 3-р сарын 12-нд Тэргүүн Зөвлөл болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга КОВИД-19 цар тахлын нөлөөний улмаас Сүмийн олон нийтийн бүх цуглааныг дэлхий даяар түр хугацаагаар зогсоосноо зарласан.

Бид энэ захидлаараа, одооноос эхлэн зарим цуглаан, үйл ажиллагааг хязгаарлалттай, үе шаттайгаар эрсдэлгүй эргэн явуулж эхлэхийг зөвшөөрч байна. Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга болон өөрсдийг нь хянадаг Далын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран бүсийнхээ хүрээнд цуглаанаа хэзээ хаана явуулж эхлэхээ шийднэ. Болгоомжтой байж, орон нутгийн хууль тогтоомжийг баримтлан, 1 эсвэл 2-р үе шатанд гэх мэтчилэн хэвийн үйл ажиллагаандаа эргэж орох хугацааг нь гадас, тойргийн удирдагчдад мэдээлнэ.

Энэхүү захианд энэ үйл явцыг удирдан чиглүүлэх зарчим, дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан. Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд нөхцөл байдлаас хамааран үүнийг өөрчилж болно. Гадасны ерөнхийлөгч бүр Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зааврын дагуу мөн бишопуудтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр гадас, тойргийн цуглаан, үйл ажиллагааг явуулж эхлэх тодорхой цаг хугацааг тогтооно.

Бид гишүүдийнхээ гэр орондоо шүтэн биширсэн итгэлд мөн шүтэн биширч, үйл ажиллагаа явуулахын тулд цугласнаар ирэх адислалууддаа талархаж байна.

Хүндэтгэсэн,







Тэргүүн Зөвлөл

Сүмийн цуглаан, үйл ажиллагаанд эрсдэлгүй эргэж орох заавар

2020 оны 5-р сарын 19



2020 оны 3-р сарын 12-нд Тэргүүн Зөвлөл болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга КОВИД-19 цар тахлын нөлөөний улмаас Сүмийн бүх олон нийтийн цуглааныг дэлхий даяар түр хугацаагаар зогсоосноо зарласан.

Орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжийн дагуу зөвшөөрч, Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс орон нутгийн удирдагчдад мэдэгдэл хийсэн цагт цуглаан, үйл ажиллагаандаа үе шатлалтайгаар эргэж орохыг Ах нар одооноос зөвшөөрч байна. Ийм зөвшөөрлийг танай газар нутагт олгосон тохиолдолд орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжинд үндэслэн болгоомжтой, сайтар төлөвлөн, зохион байгуулалттай хийнэ үү.

Ерөнхий удирдамж

Хавсралт дахь 2020 оны 4-р сарын 16-ны Тэргүүн Зөвлөлийн [Хүнд бэрх цаг үед баримтлах удирдлагын зарчмууд](#) захидлыг [Хүнд бэрх цаг үед баримтлах удирдлагын зарчмууд](#) хавсралтын хамт, [Шаардлагатай ёслол, адислалууд болон Сүмийн бусад үйл ажиллагаанд зориулсан удирдамж](#) зэргийг үзнэ үү. Мөн [КОВИД-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээ](#) нэртэй баримтыг үзнэ үү.

Дараах нэмэлт зарчим, зааварчилгааг харгалзан үзнэ үү. Үүнд:

- Гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс туйлын хянамгай, болгоомжтой хандана уу. Ялангуяа эрүүл мэндийн асуудалтай, насны хувьд өндөр эрсдэлтэй гишүүдэд анхаарлаа хандуул.
- Биеийн байдал тааруу байгаа, өөрийгөө тусгаарлах заавар авсан мөн халуурах, ханиалгах, амьсгаа давчдах, толгой өвдөх, нус гоожих, хоолой өвдөх зэрэгшинж тэмдэг илэрсэн хүмүүсийг цуглаанд оролцохгүй байхыг зөвлө.
- [Нийтийн эзэмшлийн](#) газарт зай барих, гараа угаах болон “[Preventative Measures for Members](#)”- т өгөгдсөн зааврыг ажил хэрэг болгон мөрдөнө үү.
- Байршил бүрд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, цуглааны хэр хэмжээ, давтамж, үргэлжлэх цагийн талаарх засгийн газрын хууль тогтоомжийг дагаж, хэрэгжүүлнэ үү.
- Хэвийн үйл ажиллагаандаа аажим орж, үргэлжлүүлэн техник технологи ашиглан, зайнаас ажиллахын зэрэгцээ доор дурдсанаар биеэр ирж оролцох хурал, цуглаанд үе шаттайгаар орно уу. Юуны өмнө баптисм, ариун ёслол гэх мэт ёслолуудыг гүйцэтгэх цуглаануудыг түрүүлэн хийх ёстой.

Сүмийн цуглаан, үйл ажиллагаанд эрсдэлгүй эргэж орох заавар

2020 оны 5-р сарын 19

Үе шаттай явуулах арга хэмжээ

Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын болон өөрсдийг нь удирддаг Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвшөөрлөөр 1 эсвэл 2-р үе шатанд гэх мэтчилэн хэвийн үйл ажиллагаандаа эргэж орох хугацааг гадас, тойргийн удирдагчдад мэдээлнэ. Дараах хүснэгтэд өгсөн жишээнүүдийг харж болох ба эдгээрийг Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөл нөхцөл байдлаас хамааран өөрчилж болно. Гадасны ерөнхийлөгч бүр Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зааврын дагуу мөн бишопуудтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр гадас, тойргийн цуглаан, үйл ажиллагааг явуулж эхлэх тодорхой цаг хугацааг тогтооно.

Цуглаан	1-р үе шат	2-р үе шат
Хүндэтгэлийн өдөр	Орон нутгийн засгийн газрын хууль журмын дагуу цуглааны байруудад 99 хүртэл тооны гишүүнтэй богиносгосон цуглаан явуулах	Орон нутгийн засгийн газрын хууль журмын дагуу цуглааны байруудад 100 болон түүнээс тооны дээш гишүүнтэй цуглаан явуулах
Оршуулга, гэрлэх ёслол зэрэг бусад цуглаан, үйл ажиллагаа	Орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжийн дагуу богиносгосон цуглаан хийх эсвэл техник технологи ашиглан, зайнаас явуулах	Орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжийн дагуу цуглааны байранд цугларах

Олон нийтийн газарт хоорондын зай барих. Цуглаан, хичээлийн үеэр болон ариун ёслолын танхим, ангиуд руу орж, гарахдаа зохих хэмжээнд зай барих арга замыг бодож үзээрэй. Нэг өрх гэрийнхэн хамтдаа сууж болох ч бусад хүн зохих хэмжээнд зай барин суух ёстой. Найрал дууг түр хугацаагаар зогсоохыг зөвлөж байна.

Илүү олон гишүүн оролцохыг хүссэн тохиолдолд. Дээрх зааварт зөвшөөрөгдсөнөөс олон гишүүн оролцохыг хүсвэл удирдагчид өдрийн туршид олон цуглаан зохион байгуулж эсвэл гишүүдийг долоо долоо хоногоор ээлжлэн оролцоход урьж болно.

Нэг цуглааны байран дахь олон тойрог, салбар. Нэг цуглааны байранд нэгээс олон тойрог, салбар цуглардаг бол гадасны ерөнхийлөгчид цуглаанууд давхцахаас сэргийлж, түр хугацаанд цуглааны хуваарийг өөрчлөх хэрэгтэй.

Том тойргуудтай бүсүүд. Олон хүн цуглаанд ирдэг тойргууд 2-р түвшинд хүртлээ цуглаан хийхээ түр азнавал зохино. Мөн эдгээр тойрог бүх гишүүнээ хамруулахын тулд долоо долоо хоногоор ээлжлэх хэрэгтэй. Цуглааны байранд

Сүмийн цуглаан, үйл ажиллагаанд эрсдэлгүй эргэж орох заавар

2020 оны 5-р сарын 19

очоогүй ням гаргуудад тэд гэртээ шүтэн бишрэх цуглаанаа хийж болох ба бишопын зөвшөөрлөөр зохистой санваар атгагч нараар гэртээ ариун ёслол түгээлгэж болно.

Хүүхдийн хэсэг. 1, 2-р үе шатны үеэр балчир болон бага насны Хүүхдийн хэсгийн ангийг оруулах эсэхээ удирдагчид шийднэ. Тэд бас дуулах цаг, хичээлүүдийг оруулах эсэхийг шийдэж болно.

Ариутгах арга хэмжээ. Удирдагчид цуглаан бүрийн дараа байраа, ялангуяа хаалганы бариул, гэрлийн унтраалга, ус уух хэсэг, микрофон, индэр зэрэг гар хүрдэг хэсгүүдийг сайтар цэвэрлэхэд анхаар. Тойргууд гар угаах тэмдгийг ариун цэврийн өрөөнд тавьж болно. Боломжтой газруудад гар ариутгагчийг цуглааны байрын хүлээн авах хэсэгт тавих нь зүйтэй. Орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжийн дагуу амны хаалт зүүхийг гишүүдэд уриалж болно. Нөхцөл байдал хэвийн болтол тойргууд хөтөлбөр хэвлэж тараахаа зогсоох нь зүйтэй.

Хүүхдийн адислал. Бишоп хүүхдийн адислалыг тухайн гэр бүлийн гэр оронд эсвэл цуглааны байранд өгөхийг зөвшөөрч болно.

Баптисм ба гишүүний баталгаа. Баптисм хүртэх, гишүүнээр батлахад зохих түлхүүрүүдийг атгаж буй санваарын удирдагчдаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Баптисмын үйл ажиллагааг хамгийн багадаа 4 эсвэл зөвшөөрөгдсөн газарт үүнээс олон хүнтэй зохион байгуулж болно. Бусад хүн баптисм хүртээхийг техник технологи ашиглан, зайнаас үзэж болно. Ариун ёслолын цуглаан хэвийн хуваарьт орох хүртэл хөрвөгчдийг ариун ёслол дээр бус, харин баптисмын дараа шууд гишүүнээр баталж болно. Түүнчлэн бишопын удирдлаган доор зохих насны эрэгтэйчүүдэд баптисм хүртээж, гишүүнээр баталсных нь дараа шууд Аароны санваар хүртээж болно.

Ариун ёслол түгээх - Ерөнхий зарчим

Гишүүдийг эрүүл, аюулгүй байлгах үүднээс ариун ёслолыг хаана түгээхээс үл хамааран үүнийг бэлтгэх, түгээхдээ санваар атгагч нар дараах ерөнхий зааврыг ямар ч үед баримтлах ёстой. Үүнд:

- Бие нь сайнгүй байгаа санваар атгагч нар гэртээ үлдэх хэрэгтэй.
- Боломжтой газруудад санваар атгагч нар ариун ёслолыг бэлдэж, адисалж, түгээхдээ амны хаалт зүүнэ. Нэг Аароны санваартанг ариун ёслолыг бэлтгэх, адислах эсвэл түгээхтэй холбоотой туршлагаасаа хүүхдүүдэд ярьж өгөхөд урь.
- Санваар атгагч нар ариун ёслолыг бэлдэж, адисалж, түгээхийнхээ өмнө гараа хамгийн багадаа 20 секунд савандаж, усаар сайтар угаах ёстой. Хэрэв гараа угаах боломжгүй бол спиртэн суурьтай гар ариутгагч ашиглана. Үүний дараа тэд ариун ёслолыг бэлдэж, адисалж, түгээхийн өмнө гар барих, нүд, хамар, амандаа хүргэхээс зайлсхийнэ.

Сүмийн цуглаан, үйл ажиллагаанд эрсдэлгүй эргэж орох заавар

2020 оны 5-р сарын 19

- Хүн бүр ханиалгаж, найтаахдаа цаасан амны алчуураар ам хамраа дарах ёстой. Үүний дараа цаасыг хогийн саванд хаяж, гараа угаах эсвэл ариутгах хэрэгтэй. Ариун ёслолын тавиурын гадаргууг бариулын хамт тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлэх хэрэгтэй.

Гэрт ариун ёслол түгээх

- Зарим гишүүн хэсэг хугацаанд цуглах боломжгүй байж болох ба тэдэнд нэг бүрчлэн тохинуулах хэрэгтэй. Цашилбал, бишоп нь шаардлагатай газруудад гэртээ ариун ёслол бэлтгэж, хүртэх зөвшөөрлийг зохистой санваар атгагч нарт өгч болно. Хэрэв гэрт нь зохистой санваар атгагч байхгүй бол хүсэлт гаргасан гишүүдийн гэрт тойргийн бусад зохистой санваар атгагчид ариун ёслол бэлтгэж, түгээх зөвшөөрлийг бишоп өгч болно.

Цуглааны байруудад ариун ёслол түгээх*

- Бишопууд ариун ёслолыг түгээхэд өөрчлөлт гаргах эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй. Жишээлбэл, гишүүдийг нэг суудал алгасан суухад урих эсвэл сандлуудыг зайтай байрлуулбал санваар атгагч нарт ариун ёслолын тавиурыг эгнээнд суусан хүмүүсээр дамжуулуулахын оронд гишүүн бүрд хүргэж түгээх боломжтой болно.

**Эдгээр зарчмыг хэрхэн зөв хэрэгжүүлэхийг харуулсан зургуудыг [Newsroom.ChurchofJesusChrist.org](https://www.newsroom.churchofjesuschrist.org)-оос үзнэ үү.*